

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2009 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч С.Батдэлгэр

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Бид өнгөрсөн жилд шүүхийн захиргааны удирдлага, түүн дотроо баримт бичиг боловсруулах, хэвлэмэл хуудас хэрэглэх, тамга, тэмдэг түших харилцааг эрх зүйн журамд оруулах, гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх, өмнө нь тогтоосон найрсаг хамтын ажиллагааг тал бүрээр өргөжүүлэх, цар хүрээг нь нэмэгдүүлэх, гадаад улс дахь шүүгчдийн сургалтыг тогтмолжуулж, түүний үр өгөөжийг дээшлүүлэх, Улсын Дээд шүүхээс хууль тайлбарласан албан ёсны тайлбарыг эмхтгэн нийтийн хүртээл болгох зэрэг зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарч үүнд та бүхний идэвхи зүтгэл, санал санаачлага хамгаас чухал байсныг тэмдэглэхэд таатай байна.

Шүүхийн байгууллагатай хамтран ажиллаж, өдөр тутмын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэн үр бүтээлтэй ажиллаж буй ЦЕГ-н Ерөнхий нягтлан бодогч, Санхүү, ар талын газрын Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа С.Уранцэцэг, МҮОНР-ийн “Хурд” агентлагийн сурвалжлагч Д.Бат-Орших нарын 6 хүнийг Ерөнхий шүүгчийн захирамжаар Улсын Дээд шүүхийн “**Жуух бичиг**”-ээр тус тус шагналаа.

2009 он эрдмийн ургац арвин, номын өгөөж дэлгэрсэн он болж өнгөрлөө. Тухайлбал,

- Улсын Дээд шүүхээс 2007-2009 онд хууль тайлбарласан тогтоолыг эмхтгэн хуулийн албан ёсны тайлбарын эмхэтгэл;
- “Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмжийн эмхтгэл”;
- “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” номын 2 дахь хэвлэлт;
- “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” ном;
- “Шүүхийн 2008 оны ажлын тайлан” зэргийг хэвлүүлж олны хүртээл болголоо.

Мөн одоо “**Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар**”, “**Иргэний хуулийн дэлгэрэнгүй тайлбар**”-ууд бүтээгдэж байна.

Улсын Дээд шүүхээс процессийн эрх зүйн чиглэлүүдээр дэлгэрэнгүй тайлбар гаргаж буй нь байцаан шийтгэх ажиллагааны зохицуулалтыг шинжлэх ухаан, онол, хууль зүйн техникийн үүднээс тайлбарлах явдлыг гүнзгийрүүлж, хэргийн болон бусад оролцогчдийн эрх зүйн байдал, шүүхээс хэрэгжүүлэх тодорхой ажиллагаануудыг шинжлэн, тодотгосон олон талын ач холбогдолтой бүтээл боллоо гэж үзэж байна.

2009 оны 2 дугаар сарын 06-ны өдөр Шүүгчдийн зөвлөл хуралдаж, ШЕЗ-ийн гишүүнээр:

- Улсын Дээд шүүхээс Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Д.Батсайхан**, шүүгч **Д.Тунгалаг**,
- давж заалдах шатны шүүхээс Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, Дорнод аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Батсүрэн** нарыг,

Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр:

- Улсын Дээд шүүхээс Иргэний хэргийн танхимын тэргүүн **Ц.Амарсайхан**, шүүгч **Л.Атарцэцэг**, **Б.Доржготов**,
- Давж заалдах шатны шүүхээс Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн **Ц.Өрнөндэлгэр**, Говьсүмбэр аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч **Г.Лхагвамаа**, Дундговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч **Ш.Төмөрбаатар** нарыг,

Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр:

- Улсын Дээд шүүхээс Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа**, шүүгч **Ц.Сумъяа**,
- Давж заалдах шатны шүүхээс Булган аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч **Ё.Бямбацэрэн**, Хэнтий аймгийн шүүхийн шүүгч **Б.Сүхгомбо**,

- Анхан шатны шүүхээс Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч **Б.Баатар**, Өвөрхангай аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч **Т.Даваасүрэн** нарыг тус тус сонгов.

Мөн хурлаар Монголын шүүгчдийн холбооны тэргүүнээр Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Д.Батсайханыг** томиллоо.

Түүнчлэн Шүүхийн мэргэжлийн хороо болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны 2008 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцлээ.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа. Ингээд Улсын Дээд шүүхийн 2009 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.



Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар

Нийт шүүгчдийн хуралдаан:

2009 онд нийт шүүгчдийн хуралдааныг **11** удаа зарлан, нийт **11** өдөр хуралдаж, бүгд **33** асуудал хэлэлцэж, тэмдэглэл **1**, тогтоол **32** гаргасны дотор, эрүүгийн **12**, иргэний **1** хэрэг тус тус хянан шийдвэрлэж, хууль тайлбарласан **19** тогтоол гаргаж, Булган, Дорноговь, Дорнод, Төв, Сэлэнгэ аймгийн болон Нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүдийн ажлыг шалган тусалсан дүнг хэлэлцэн тэмдэглэл гаргасан байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо **14**-өөр, эрүүгийн хэрэг **14**-өөр, иргэний хэрэг **2**-оор, захиргааны хэрэг **1**-ээр тус тус буурч, хуулийн тайлбар **3**-аар нэмэгджээ.

Нийт шүүгчдийн хуралдааны үзүүлэлт



2009 оны шүүн таслах ажиллагааны тайланг товч танилцуулбал:


1. Эрүүгийн хэргийн танхим:

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 21 хэрэг дээр хяналтын журмаар эрүүгийн 488, цагаатгалын 48, Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасан 72, нийт 629 хэрэг хүлээн авчээ.

Өмнөх онтой харьцуулахад хяналтын журмаар хүлээн авсан хэрэг 148-аар буурч, цагаатгалын хэрэг 21-ээр нэмэгдэж, Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдол 21-ээр буурчээ.

Тайлангийн хугацаанд 443 эрүүгийн, 42 цагаатгалын буюу 485 хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, 65 хэргийг хянан буцааж, 72 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 7 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 629 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 80 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 6.1 хэрэг хэлэлцжээ.


Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 485 хэргийн 46.4 хувь буюу 225 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 24.5 хувь буюу 119 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 29.1 хувь буюу 141 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан 119 тогтоол, магадлалын 10.1 хувь буюу 12 нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, 4.2 хувь буюу 5 нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, 1.7 хувь буюу 2 нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, 84 хувь буюу 100 шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон 141 тогтоол, магадлалтай хэргээс 54 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, 23 хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, 42 хэргийг хэрэгсэхгүй болгож, 18 хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон, 1 хэргийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, магадлалыг хэвээр үлдээж, шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон 3 хэрэг байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Д.Батсайхан 103, шүүгч Б.Бат-Эрдэнэ 120, Ч.Ганбат 92, Б.Доржготов 120, С.Нямжав 121, шүүгч Ч.Тунгалаг 1, Ерөнхий шүүгчийн ажлын алба 72 эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.


Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн **Д.Батсайхан 439**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 433**, **Ч.Ганбат 346**, **Б.Доржготов 450**, **С.Нямжав 434** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн **Д.Батсайхан 368**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 29**, **Ч.Ганбат 14**, **Б.Доржготов 27**, **С.Нямжав 23**, Иргэний хэргийн танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 8**, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа 16** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Танхимын тэргүүн **Д.Батсайхан 71**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 103**, **Ч.Ганбат 81**, **Б.Доржготов 114**, **С.Нямжав 115**, **Ч.Тунгалаг 1** хэрэг тус тус илтгэсэн байна.



Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **42** хэргийн **2** хэрэг нь хэлмэгдэгсдийн овог, нэрийг өөрчилж, **74** хүнд холбогдох **39** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, **1** хэргийн тогтоолыг хэвээр үлдээжээ.

Нийт шүүгчдийн хуралдаанаар эрүүгийн **12** хэрэг хянан хэлэлцэгдсэний **3** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **9** нь цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтанд холбогдох хэрэг байв.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **81.4** хувь буюу **395** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **8.5** хувь буюу **41** нь улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **10.1** хувь буюу **49** нь прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн **Д.Батсайхан 32**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 17**, **Ч.Ганбат 4**, **Б.Доржготов 6**, **С.Нямжав 6** хэргийг тус тус хянан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн, гомдол гаргах хугацаа хэтэрсэн үндэслэлээр, мөн Ерөнхий шүүгчийн ажлын алба **67** хэргийг хянан зохих хариуг өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим **2009** онд нийт **83** албан бичиг, **173** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн **Д.Батсайхан 79** албан бичиг, **153** өргөдөл гомдол, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 2** албан бичиг, **5** өргөдөл гомдол, **Ч.Ганбат 1** өргөдөл гомдол, **Б.Доржготов 2** албан бичиг, **2** өргөдөл гомдол, **С.Нямжав 5** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо албан бичгийн үлдэгдэлгүй, харин цагаатгалын ажилтай холбоотой **7** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн **Д.Батсайхан 23** удаа оролцсоноос **5** удаа шүүх хуралдааныг даргалж, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 43, Ч.Ганбат 25, Б.Доржготов 76, С.Нямжав 43**;

Захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн **Д.Батсайхан 57** удаа оролцсоноос **16** удаа шүүх хуралдааныг даргалж, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 59, Ч.Ганбат 38, Б.Доржготов 67, С.Нямжав 48** удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **93**-ыг гаргаснаас Танхимын тэргүүний “шүүхийн харъяалал тогтоох тухай” захирамж **63**, бусад захирамж **30** байна.


2.Иргэний хэргийн танхим:

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **18** хэрэг дээр хяналтын журмаар иргэний **814**, Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасан **168**, шинээр илэрсэн нөхцөл байдал тооцуулахаар **60**, нийт **1060** хэрэг хүлээн авчээ.

Өмнөх онтой харьцуулахад хяналтын журмаар хүлээн авсан хэрэг **181**-ээр, Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдол **20**-оор тус тус нэмэгджээ.

Тайлангийн хугацаанд **746** хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, **36** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **56** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **156** хэрэгт Ерөнхий шүүгчийн ажлын албанаас зохих хариуг өгч, Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр **1** хэрэг хянагдаж, одоо **65** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1060 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны болон шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар ирүүлсэн хүсэлтийг шүүх хуралдаанаар нийт **63** өдөр хуралдан шийдвэрлэж, **өдөрт** дунджаар **12.7** хэрэг хэлэлцэж, нийт **802** хянаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **746** хэргийн **55.9** хувь буюу **417** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **13.3** хувь буюу **99** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **30.8** хувь буюу **230** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **99** шийдвэр, магадлалын **58.5** хувь буюу **58** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **41.5** хувь буюу **41** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **230** шийдвэр, магадлалтай хэргээс **78** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **31** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, **121** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **78** хэргийн **55.2** хувь буюу **43** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **44.8** хувь буюу **35** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 146**, шүүгч **Л.Бямбаа 218, А.Доржготов 218, Д.Тунгалаг 103, Б.Ундрах 201** иргэний хэрэг тус тус хүлээн авчээ.


Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг



Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Иргэний танхимын тэрнүүн **Ц.Амарсайхан 760**, шүүгч **Л.Бямбаа 745**, **А.Доржготов 734**, **Д.Тунгалаг 409**, **Б.Ундрах 687** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 642**, шүүгч **Л.Бямбаа 23**, **А.Доржготов 56**, **Д.Тунгалаг 7**, **Б.Ундрах 32**, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Д.Батсайхан 5**, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **О.Зандраа 37** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 118**, шүүгч **Л.Бямбаа 198**, **А.Доржготов 201**, **Д.Тунгалаг 98**, **Б.Ундрах 187** хэрэг тус тус илтгэсэн байна.



Нийт шүүгчдийн хуралдаанаар иргэний 1 хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр хянан хэлэлцсэн байна.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **43.6** хувь буюу **325** нь нэхэмжлэгчийн, **55.8** хувь буюу **416** нь хариуцагчийн, **0.6** хувь буюу **5** нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим **2009** онд нийт **65** албан бичиг, **71** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 58** албан бичиг, **62** өргөдөл гомдол, шүүгч **Л.Бямбаа 1** албан бичиг, **А.Доржготов 1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, **Д.Тунгалаг 2** албан бичиг, **Б.Ундрах 2** албан бичиг, **1** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо **1** албан бичиг, **7** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 20** удаа оролцсоноос **8** удаа шүүх хуралдааныг даргалж, шүүгч **Л.Бямбаа 40**, **А.Доржготов 17**, **Д.Тунгалаг 4**, **Б.Ундрах 50** оролцсон;

Захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн **Ц.Амарсайхан 47** удаа оролцсоноос **6** удаа шүүх хуралдааныг даргалж, **1** хэрэг илтгэсэн, шүүгч **Л.Бямбаа 52**, **А.Доржготов 49**, **Д.Тунгалаг 32**, **Б.Ундрах 68** удаа тус тус оролцжээ.

Түүнчлэн Улсын Их хурлын сонгуулийн 24 дүгээр тойргийн нөхөн сонгуульд нам, эвслээс болон бие даан нэр дэвшигч **19** хүний өр, төлбөрийн талаарх тодорхойлолтыг хуулийн дагуу хугацаанд нь гаргаж, нэр дэвшигч нарт болон Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **718-г** гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **15**, “Гомдолд гаргаагүйд тооцох тухай” **9**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” шүүгчийн захирамж **105**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **555**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” захирамж **24**, бусад захирамж **10** байна.

3. Захиргааны хэргийн танхим:

Захиргааны хэргийн танхим давж заалдах болон хяналтын журмаар өмнөх оны үлдэгдэл давж заалдах журмаар гомдол гаргасан **20**, хяналтын журмаар гомдол гаргасан **11**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **4**, бүгд **35** хэрэг дээр давж заалдах журмаар **501**, хяналтын журмаар **279**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **44**, нийт **859** хэрэг хүлээн авчээ.


Өмнөх онтой харьцуулахад давж заалдах журмаар хүлээн авсан хэрэг **101**-ээр, хяналтын журмаар хүлээн авсан хэрэг **68**-аар тус тус нэмэгдэж, Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдол **5**-аар буурчээ.

Тайлангийн хугацаанд **давж заалдах журмаар 476** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **8** хэргийг хянан буцааж, одоо **37** хэргийн;

Хяналтын журмаар 241 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, **12** хэргийг хянан буцааж, одоо **37** хэргийн;

Ерөнхий шүүгчид хянуулахаар ирүүлсэн **48** хэргээс **43** хэрэгт албан бичгээр хариу өгч, одоо **5** хэргийн тус тус үлдэгдэлтэй байна.

**Давж заалдах болон хяналтын журмаар
нийт хүлээн авсан 859 хэргээс**



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **35** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **6.8**, давж заалдах шатны шүүх хуралдаан нийт **41** өдөр хуралдаж, өдөрт дундажаар **11.6** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд давж заалдах журмаар ирүүлсэн **521** хэргээс нэг шүүгчид **104**, хяналтын шатны журмаар ирүүлсэн **290** хэргээс нэг шүүгчид **48.3** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн захиргааны **241** хэргийн **65.1** хувь буюу **157** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **9.9** хувь буюу **24** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **22.9** хувь буюу **55** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн **2.1** хувь буюу **5** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Өөрчлөлт оруулсан **24** шийдвэр, магадлалын **33.3** хувь буюу **8** нь хууль буруу хэрэглэсэн, **25.1** хувь буюу **6** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **41.6** хувь буюу **10** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **55** шийдвэр, магадлалтай хэргээс **47.2** хувь буюу **26** хэргийг хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **9.1** хувь буюу **5** хэргийг хэрэгсэхгүй болгож, **23.6** хувь буюу **13** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон **20.1** хувь буюу **11** хэрэг байна.


Давж заалдах журмаар хэлэлцэгдсэн захиргааны **476** хэргийн **64.2** хувь буюу **305** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **9.8** хувь буюу **47** хэргийн шийдвэрт өөрчлөлт оруулж, **25.2** хувь буюу **120** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн **0.8** хувь буюу **4** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Өөрчлөлт оруулсан **47** шийдвэрийн **51.1** хувь буюу **24** нь хууль буруу хэрэглэсэн, **48.9** хувь буюу **23** нь нотлох баримтыг буруу үнэлсэн гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **120** шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргээс **47.5** хувь буюу **57** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **31.6** хувь буюу **38** нэхэмжлэл болон хэргийг хэрэгсэхгүй болгож, **15.1** хувь буюу **18** хэргийн шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг хангаж, **5.8** хувь буюу **7** шүүгчийн захирамж, тогтоолыг хүчингүй болгож, өөрийн магадлалаар шийдвэрлэсэн байна.

Танхимын тэргүүн О.Зандраа хяналтын журмаар **40**, давж заалдах журмаар **1**, шүүгч Л.Атарцэцэг давж заалдах журмаар **105**, хяналтын журмаар **53**, Д.Пунцаг давж заалдах журмаар **102**, хяналтын журмаар **49**, Ц.Сумъяа давж заалдах журмаар **106**, хяналтын журмаар **50**, Ч.Тунгалаг давж заалдах журмаар **101**, хяналтын журмаар **46**, П.Цэцгээ давж заалдах журмаар **106**, хяналтын журмаар **52** захиргааны хэрэг тус тус **хүлээн** авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Давж заалдах шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Л.Атарцэцэг **80**, Д.Пунцаг **75**, Ц.Сумъяа **97**, Ч.Тунгалаг **100**, П.Цэцгээ **112** удаа тус тус **оролцож**;

Шүүгч Л.Атарцэцэг **104**, Д.Пунцаг **83**, Ц.Сумъяа **128**, Ч.Тунгалаг **79**, П.Цэцгээ **76**, захиргааны хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Л.Атарцэцэг **94**, Д.Пунцаг **93**, Ц.Сумъяа **96**, Ч.Тунгалаг **94**, П.Цэцгээ **99** хэрэг тус тус **илтгэсэн** байна.


Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2009 оны ажлын ачаалал /давж заалдах шат/



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Л.Атарцэцэг **53**, Д.Пунцаг **36**, Ц.Сумъяа **19**, Ч.Тунгалаг **65**, П.Цэцгээ **34** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн О.Зандраа **209**, Л.Атарцэцэг **2**, Д.Пунцаг **2**, Ц.Сумъяа **4**, Ч.Тунгалаг **3**, П.Цэцгээ **2** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Танхимын тэргүүн О.Зандраа **34**, Л.Атарцэцэг **45**, Д.Пунцаг **35**, Ц.Сумъяа **38**, Ч.Тунгалаг **43**, П.Цэцгээ **46** хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **55.8** хувь буюу **400** нь нэхэмжлэгчийн, **34.9** хувь буюу **250** нь хариуцагчийн, **9.3** хувь буюу **67** нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим **2009** онд нийт **47** албан бичиг, **27** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн О.Зандраа **11** албан бичиг, **14** өргөдөл гомдол, шүүгч Л.Атарцэцэг **11** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Д.Пунцаг **7** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Ц.Сумъяа **6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Ч.Тунгалаг **6** албан бичиг, **1** өргөдөл гомдол, П.Цэцгээ **5** албан бичиг, **2** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо **1** албан бичиг, **4** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа **37** удаа оролцсоноос **16** удаа шүүх хуралдааныг даргалж, бүрэлдэхүүнд **21**, шүүгч Л.Атарцэцэг **35**, Д.Пунцаг **21**, Ц.Сумъяа **38**, Ч.Тунгалаг **33**, П.Цэцгээ **27**;

Иргэний хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа **75** удаа оролцсоноос **37** удаа шүүх хуралдааныг даргалж, бүрэлдэхүүнд **38**, шүүгч Л.Атарцэцэг **70**, Д.Пунцаг **60**, Ц.Сумъяа **95**, Ч.Тунгалаг бүрэлдэхүүнд **66**, илтгэсэн **1**, П.Цэцгээ **49** удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **907**-г гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **4**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” шүүхийн тогтоол **66**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн захирамж **11**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **788**, харъяалал тогтоосон захирамж **29**, бусад захирамж **9** байна.

Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн асуудлын цөм нь хуулийг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах явдал билээ.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийт **19** тогтоол гаргаж, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд нийтлүүлэх, өөрийн вэб сайтад байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болголоо. Үүнд:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Л.Атарцэцэг/;
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Ц.Сумъяа/;
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/;
4. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/;
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан/;
6. Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Ч.Ганбат/;
7. Иргэний хуулийн 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Б.Ундрах/;
8. Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Л.Бямбаа/;

9. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай /шүүгч Д.Пунцаг/;
10. Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч А.Доржготов/;
11. Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Б.Бат-Эрдэнэ/;
12. Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч Б.Доржготов/;
13. Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /шүүгч С.Нямжав/;
14. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны тухай 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/;
15. “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Б.Доржготов/;
16. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/;
17. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн зарим зүйл, заалтыг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/;
18. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/;
19. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ зэрэг болно.

Дээрх хуулийн тайлбарууд нь тодорхой төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудлаар гарч байсан хүндрэл бэрхшээлийг арилгах, хуулийг нэр мөр ойлгож, зөв хэрэглэх, тодорхой төрлийн хэргийн зүйлчлэлийг хэргийн нөхцөл байдалд тохируулан оновчтой тогтоох, зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах иргэдийн баталгаа нэмэгдэх, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд шүүхийн үйл ажиллагаанд баримт бичиг хөтлөх нэгдсэн стандарт тогтоох, шүүгч, шүүхийн ажилтны албан томилолтоор ажиллах нөхцлийг эрх зүйн зохицуулалтад оруулах, иргэд, хуулийн этгээдэд хүнд сурталгүй, чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилгээг үзүүлэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, шүүхийн захиргааны удирдлага, түүний менежментийг шинэ түвшинд гаргах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, зөв хувиарлах, зохион байгуулах чиглэлд илүү анхаарч ажиллалаа. Тухайлбал энэ оны байдлаар:

1. “Шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх тухай журам” 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн №15 тоот Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамж;
2. “Шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны заавал хөтлөх баримт бичгийн жагсаалт” 2009 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн №61 тоот Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамж;
3. “Шүүгч, ажилтанд албан томилолт олгох, дүгнэх тухай журам” 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн №15 тоот Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамж зэргийг тус тус батлан гаргажээ.

Мөн хугацаанд **эрүүгийн** хэргийн танхим зөвлөмж **4**, тойм **3**, **иргэний** хэргийн танхим зөвлөмж **5**, тойм **4**, **захиргааны** хэргийн танхим зөвлөмж **5**, тойм **3**-ийг нийт зөвлөмж **14**, тойм **12**-ыг гарган шүүхүүдэд хүргүүлснээс гадна “Дээд шүүхийн Мэдээлэл” сэтгүүлд хэвлүүллээ.

Улсын Дээд Шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчид **Сэлэнгэ, Дорноговь, Төв, Дорнод, Булган** аймгийн болон Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн ажлыг шалган туслаж, мэргэжлийн удирдлагаар ханган, холбогдох сургалтыг зохион байгууллаа.

Нийт шүүгчдийн хуралдаанаар дээрхи шүүхүүдийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэж **тогтоол** гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүллээ.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээртэй уялдуулан гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллаа.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2008 оны байдлаар гаргуулан авч, 17 шүүгчийн материалыг “Авлигатай тэмцэх газар”-т хүргүүлж, захиргааны албан хаагч 41 хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна.

Шүүгч, ажилтнуудын нөхөн тоо бүртгэлийг зохих журмын дагуу тайлагнаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлжээ.

Тамгын газрын даргын зөвлөл 4 удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт 20 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт тушаал гаргасан байна.

Одоо тамгын газрын харъяа албадын ажлын талаар товч дурдья.

1. Ерөнхий шүүгчийн ажлын алба

Тус алба нь тайлангийн хугацаанд 18 албан бичиг, 197 өргөдөл, гомдол, хүлээн авч цаг тухайд нь хариуг нь өгсөн бөгөөд одоо 3 өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн 72, иргэний 174, захиргааны 48, нийт 294 хэрэг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулснаар Ерөнхий шүүгч эрүүгийн 3, иргэний 1 хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр дүгнэлт бичиж, Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт бичигдээгүй 266 хэрэгт хариу өгчээ. Өмнөх онтой харьцуулахад эрүүгийн хэрэг 21-ээр өсч, харин иргэний хэрэг 16-аар, захиргааны хэрэг 1-ээр тус тус буурчээ. Одоо тус алба нь эрүүгийн 2, иргэний 17, захиргааны 5 хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Ерөнхий шүүгч, түүний ажлын албаны дарга нар бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч 208 хүнийг сар бүрийн 4 дүгээр 7 хоногийн **пүрэв** гаригт хүлээн авч уулзаж, тэдний санал, хүсэлтийг сонсож, шийдвэрлэжээ.

Мөн хугацаанд тухайн алба нь Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчлийн талаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор 43 шүүгч нарт энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажилласнаас гадна шүүгчийн ёс зүйтэй холбоотой 8 өргөдөл, мэдээллийг Шүүхийн сахилгын хороонд шилжүүлсэн байна.

2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба

Тус алба нь шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор сонинд 284, телевизд 153, радиод 68, вэб сайтуудад 125 мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ. Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор 134 мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Үүний заримаас дурьдвал:

Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

- Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Нийгмийн хөтөлбөр” нэвтрүүлгээр “Залилан мэхлэх гэмт хэрэг” түүний дотроо “бусдын орон сууцыг залилан мэхлэх” хэргийн талаар нэвтрүүлэг,
- Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа “TV-5” телевизийн “Ажлын дараа” нэвтрүүлэгт оролцож, Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны онцлог, анхаарах зарим асуудлуудын талаарх ярилцлага,
- Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга М.Дамирансүрэн UBS телевизийн “Асуулт” нэвтрүүлэгт оролцож, ойн хууль тогтоомж зөрчигчдөд шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн талаарх ярилцлага,

Радиоогийн нэвтрүүлгийн хувьд:

- Монголын үндэсний олон нийтийн радиоогийн хууль эрх зүйн “Соёмбо” нэвтрүүлгээр “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдэвт нэвтрүүлэг,
- “Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах”, “хүн худалдах худалдан авах” болон “биеэ үнэлэхэд татан оролцуулах биеэ үнэлэхийг зохион байгуулах” зэрэг эрүүгийн хэрэг болон гэр бүлийн эрх зүйн маргааны талаар Монголын үндэсний олон нийтийн радиотой хамтран ажиллаж тусгай нэвтрүүлэг тус тус бэлтгэж, нэвтрүүлжээ.

Сонин, нийтлэлийн хувьд:

- Шүүхийг олон нийтэд сурталчлах, шүүн таслах ажиллагааны хууль зүйн үндсийн талаар шүүгч болон шүүхийн ажилтны **20** ярилцлага,
- Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй холбоотой **40** нийтлэл, өгүүллэг,
- Давхардсан тоогоор **16** сонинд хуулийг тайлбарласан **4** тогтоолыг бүрэн эхээр нь,
- **2009** оны **1, 2, 3** дугаар улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ зэргийг тус тус өдөр тутмын болон бусад сонинд нийлүүлсэн байна.

Хэвлэлийн бага хурлын хувьд:

- 2008 оны шүүн таслах ажиллагааны талаар хэвлэлийн бага хурал,
- Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимтай хамтран “Гэр бүлийн маргаан”-ы талаар хэвлэл мэдээллийн байгууллагын **21** сэтгүүлч оролцсон дугуй ширээний ярилцлага зэргийг тус тус зохион байгуулжээ.

Эдгээрээс гадна Захиргааны хэргийн шүүх иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх шүүхийн үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэл түгээх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт **42** мэдээллийг бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлснээс гадна Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны талаар өдрийн сурвалжлага хийж, “Үндэсний шуудан” сонинд хэвлүүлж, энэ сэдвээр Монголын үндэсний олон нийтийн радиоогийн **20** минутын нэвтрүүлгийг бэлтгэжээ.

Шүүхийн үйл ажиллагааны талаархи олон нийтийн санаа бодлыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийх зорилгоор шүүхийн талаар 2008 оны 1 дүгээр сараас 2009 оны 2 дугаар сар хүртэл хугацаанд өдөр тутмын сонингуудад нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд судалгаа хийн, түүнд тулгуурлан холбогдох албан тушаалтнууд болон анхан шатны шүүхийн шүүгч нарт танилцуулж, цаашид хэрхэн ажиллах талаар чиглэл гаргажээ.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдэд шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаа, эрх зүйн зарим асуудлаар мэдээлэл өгөх зорилгоор “Шүүхийг сурвалжлах нь” цуврал сургалтыг анх удаа хийжээ. Сургалтыг цаашид сар тутам зохион байгуулахаар боллоо.

Өдөр тутмын сонины тоймыг Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнүүдэд тогтмол бэлтгэн өгч ажиллажээ.

Цаг үеийн үйл явдалтай холбоотойгоор шүүхийн хараат бус, шүүгчийн бие даасан байдлыг хангах зорилгоор Улсын Дээд шүүх, Монголын Шүүгчдийн холбооноос гаргасан мэдэгдлийг тус бүр **4** сонин, телевизээр нэвтрүүлжээ.

Анхан, давж заалдах болон дагнасан шүүхүүдээс **2** сар тутамд шинэ мэдээ, мэдээллийг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулан, нэгтгэж, шүүхийн нэгдсэн мэдээллийн системийн вэб сайт www.judgeinfo.mn-д байрлуулж, сонинд нийтлүүлж, телевизийн урсдаг мэдээгээр олон нийтэд дамжуулсан байна.

Улсын Дээд шүүхэд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар эрүүгийн **275**, иргэний **308**, захиргааны **571** оролцогчдод утсаар болон биечлэн лавлагаа өгч, эрх зүйн мэдээллээр ханган ажиллажээ.

3. Шүүхийн судалгааны төв

Судалгааны төв нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэж буй талаар дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох, хуулийн тайлбар гаргахад судалгаа хийх, төсөл боловсруулах зэрэгт түлхүү анхааран ажиллажээ.

“Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй”, сэтгүүлийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгож байна. Мөн, “Монгол Улсын шүүхийн 2007 оны жилийн тайлан”-г эмхтгэн хэвлүүлж, Улсын Дээд шүүхийн зөвлөмж, хууль тайлбарласан тогтоол зэргийг хэвлэлтэд бэлтгээд байна.

Судалгааны ажлын хүрээнд Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн мониторингийг нэвтрүүлэх ажлын хэсэгтэй хамтран Чингэлтэй дүүргийн шүүх, Өмнөговь аймгийн шүүхийн “Шүүх, шүүгч нарын ажлын ачааллыг тодорхойлох журам боловсруулах” судалгааг гүйцэтгэж, ажлын зураглал гаргасан байна.

Түүнчлэн нийт шүүхийн хэмжээнд дагаж мөрдөх “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг хүргүүлэх заавар” боловсруулахад судалгаа хийх, санал өгөх зэргээр оролцсон байна.

Шүүн таслах ажиллагааны статистик, тоон мэдээллийг 2008 оны эхний хагас болон бүтэн жил, I, II, III, IV улирлын мэдээг нэгтгэн гаргаж, хянах ажлыг зохион байгуулсан байна.

Эрх зүйн системчлэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавих ажлыг гүйцэтгэжээ. Тухайлбал:

Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын гаргасан **38** захирамж, Шинээр хууль **116**, нэмэлт, өөрчлөлт орсон хууль **96**, хүчингүй болсон хууль **9**;

Улсын Их Хурлын шинээр баталсан **77**, өөрчлөлт оруулсан **9**, хүчингүй болсон **1** тогтоол;

Засгийн газрын шинээр баталсан тогтоол, өөрчлөлт оруулсан **15**, хүчингүй болсон **4** тогтоол;

Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол **25**, шүүн таслах ажиллагааны практик ач холбогдол бүхий эрүүгийн **62**, иргэний **85**, захиргааны **42** тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж **6**, шүүхийн мэдээллийн санд оруулжээ.

Мөн эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хоёр талын олон улсын гэрээ **15**-ыг шүүхийн мэдээллийн санд оруулжээ.

Шүүхийн ажилтнууд болон хуульчдад давхардсан тоогоор нийт **299** хүнд лавлагаа өгсөн байна.

“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” төсөл, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Ханнс-Зайделын сан зэрэг байгууллагуудтай судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтарч ажиллажээ.

4. Санхүү, хангамж, үйлчилгээний алба

5. Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба

2009 оны 9 дүгээр сарын 7-11-ний өдрүүдэд ХЗДХЯ, Үндэсний Архивын Ерөнхий газраас байгуулагдсан комисс “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийг Тамгын газрын хэмжээнд хийлээ. Тус үзлэгийн явцад баримт бичиг, архивын эмх цэгц, түүнд мэдээллийн технологийг нэвтрүүлж буй байдал, хүний нөөцийн удирдлага нь тогтоосон журам, стандартад нийцэж буй эсэхийг шалгаж, байгууллагын дүнгээр 87.2 буюу сайн үнэлгээтэйгээр дүгнэгдлээ. Улсын үзлэгийн илтгэх хуудасны мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх тодорхой ажлуудыг төлөвлөө гарган гүйцэтгэж эхлээд байна.

Тайлангийн хугацаанд тус алба нь нийт **483** өргөдөл гомдол, **721** албан бичиг, **2732** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **4040** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан өргөдөл гомдол **233**-аар буурч, албан бичиг **276**-аар, хавтаст хэрэг **600**-аар, явуулсан бичиг **410**-аар тус тус өсчээ.

Мөн хугацаанд **Р.Ганпүрэвийг** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны даргын, **Н.Хангалыг** шүүгчийн туслах - шинжээчийн, **Л.Болортуяаг** Дотоод ажил, зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд бүр болон түр хугацаагаар Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар томилж, Компьютерийн программ хангамжийн асуудал хариуцсан референт **Э.Баярбаатар**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Г.Солонго**, Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэн **Т.Майцэцэг** нар Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

Тайлангийн жилд тамгын газрын ажилтнуудын ачаалалыг тэнцвэржүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах, албан тушаалын ангилал, зэрэглэл, нэрийг оновчтой тогтоох зорилгоор Шүүхийн Ерөнхий зөвлөлөөр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлуулж, **1** орон тоог шинээр нэмж, одоо Тамгын газар нийт **63** орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлангийн хугацаанд:

- Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажиллагаа хариуцсан референт **З.Нацаг**, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах – ахлах шинжээч **Ө.Уянга** нарын **зэрэг дэвийн**;
- Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга **Ж.Наранпүрэв**, Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч **С.Сундуйжав**, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанжигүүр**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Ж.Сэмжид**, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Б.Мөнхзул**, **Б.Мягмаржав**, **Э.Халиунбаяр**, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ш.Даваадулам**, Эрүүгийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ц.Баярмаа**, Шүүхийн статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Д.Оюунчимэг**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн **Г.Гандмаа**, үйлчлэгч **Д.Оюунчимэг** нарын **үндсэн цалингийн шатлалыг**;
- Эмч **Д.Ариунболор**, үйлчлэгч **Д.Оюунчимэг** нарын **ур чадварын** нэмэгдлийг тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын баярын өдөр” зэрэг тэмдэглэлт баяруудыг тохиолдуулсан арга хэмжээг тухай бүр зохион байгуулж, ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **5** удаагийн тушаалаар **9** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Сахилгын зөрчил гаргасан **3** ажилтанд Тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Тайлангийн хугацаанд Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга **Б.Оюунбилэг** өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөж, **Ж.Сэмжид** Австрали улсын “New south walls” их сургуулийн магистрантурт суралцахаар түр чөлөөлөгдөж, **1** ажилтан амаржсаны чөлөөг үргэлжлүүлэн хүүхэд асрах чөлөөг эдлэж байна.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2009-2010 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт **5** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Нийслэлийн шүүхийн нэрэмжит 2009 оны “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын **5** төрөлт тэмцээнд Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүн **41,5** оноогоор **3** дугаар байрт шалгарлаа.

Дөрөв. Гадаад арга хэмжээний талаар

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, шүүгч, ажилтнууд гадаад сургалтад хамрагдах явдал нэмэгдэж байна.

Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх ахлах референт Н.Долгорсүрэн нар 2009 оны 1 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд **Сингапур** улсад “**Ази, Номхон далайн бүсийн шүүхийн шинэтгэл төсөл-2009**” сэдэвт уулзалт ярилцлагад оролцжээ.

Нийслэлийн шүүхийн шүүгч Д.Мөнхтуул, Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч М.Алдар, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Д.Алтанжигүүр нар 2009 оны 2 дугаар сарын 24-нөөс 3 дугаар сарын 26-ны өдрүүдэд АБНЕУ-ын **Египетийн** сангаас зохион байгуулсан “**Терроризмтой тэмцэхүй**” сэдэвт **30** хоногийн сургалтад хамрагдсан байна.

Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга Ж.Наранпүрэв, Нийслэлийн шүүхийн захиргааны хүний нөөцийн албаны дарга Д.Батхүрэл, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн референт Ц.Нарангэрэл нар 2009 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 08-ны өдрүүдэд АБНЕУ-ын **Египетийн** сангаас зохион байгуулсан “**Нийтийн захиргааны удирдлага**” сэдэвт **14** хоногийн сургалтад хамрагдлаа.

Иргэний хэргийн танхимын шүүгч А.Доржготов давж заалдах шатны шүүхийн **25** шүүгчийн бүрэлдэхүүнтэй 2009 оны 5 дугаар сарын 9-13-ны өдрүүдэд **БНХАУ-ын Бээжин хотод Ардын Дээд шүүхийн Шүүгчдийн сургалтын төвөөс зохион байгуулсан “Шүүгчдийн давтан сургалт”** сэдэвт сургалтад оролцжээ.

Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч Д.Тунгалаг нар 2009 оны 5 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд БНСУ-ын **Сөүл** хотноо зохион байгуулагдсан **“Судлаачдын хөтөлбөр-2009”** семинарт оролцсон байна.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр Японы олон улсын хамтын ажиллагааны **“Жайка”** нийгэмлэгийн төлөөлөгчдийг 2009 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун нар байлцлаа. Уулзалтын үеэр Монгол Улсын Дээд шүүх, “Жайка” нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэх **“Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”**-ийг хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцож, ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах бэлтгэл ажлыг хангах болон бусад асуудлаар санал бодлоо солилцжээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Тунгалаг, С.Нямжав, П.Цэцгээ болон зарим аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын **10** хүн 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс 9 дүгээр сарын 09-ний өдрүүдэд БНСУ-н **Сөүл** хотноо “Койка” байгууллагаас зохион байгуулсан **“Монгол Улсын шүүхийн тогтолцоог боловсронгуй болгох нь”** сэдэвт сургалтад хамрагджээ.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэрийн урилгаар БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дарга, Хятадын тэргүүлэгч их шүүгч Ван Шинзун тэргүүтэй **9** хүн 2009 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Монгол улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр хоёр орны шүүх хоорондын **хамтын ажиллагааны санамж бичгийг** өмнө тогтоосон харилцаанаас өргөн хүрээнд байгуулахаар тохиролцож, тодорхой зарим асуудлуудаар санал бодлоо солилцлоо. Түүнчлэн БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дарга, Хятадын тэргүүлэгч их шүүгч Ван Шинзун тэргүүтэй төлөөлөгчдийг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж, Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг нар хүлээн авч уулзжээ.

Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч Л.Бямбаа нарын **13** хүн 2009 оны 11 дүгээр сарын 22-29-ний өдрүүдэд ХБНГУ-ын **Хэссэн** мужийн Хууль зүйн яам, ГТХАН-тэй хамтран зохион байгуулсан **“ХБНГУ-ын шүүхийн тогтолцоон дахь дотоод ажлын зохион байгуулалт, шүүгч ажилтнуудын ажил үүргийн хуваарь, шүүхийн туслах ажилтныг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоо, шүүхийн үйл ажиллагааны программ хангамж”** зэрэг асуудлаар туршлага судаллаа.

Захиргааны хэргийн танхимын шүүгч Д.Пунцаг, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах-референт Н.Долгорсүрэн нар 2009 оны 12 дугаар сарын 9-17-ний өдрүүдэд БНЭУ-ын **Лакнау** хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 10 дугаар бага хурал”-д тус тус оролцжээ.

Тав. Сургалт, семинарын талаар

2009 оны байдлаар Улсын Дээд шүүх дараах сургалт, семинарыг зохион байгуулж, мөн оролцсон байна. Үүнд:

2009 оны 2 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын хэлтэс, албаны дарга нарын 2008 оны **нэгдсэн зөвлөгөөнийг** “Хууль зүйн үндэсний төв”-д зохион байгууллаа.

Улсын Дээд шүүх, Ханнс Зайделийн сантай хамтран **“Захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт”** сэдвийн хүрээнд 2009 оны 3 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд захиргааны хэргийн шүүхийн сургагч багш нар, судалгааны багийн гишүүдэд сургалт явуулжээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Тамгын

газрын дарга Д.Эрдэнэчулуун, Судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн нар 2009 оны 3 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлаг, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан **“Монгол Улсын хууль зүйн салбарын шинэтгэл, цаашдын зорилтууд”** сэдэвт бага хуралд оролцжээ.

Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа 2009 оны 3 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд “Эрх зүйн боловсрол” академиас Ховд аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулан зохион байгуулсан **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим”, “Захиргааны хэргийн болон нутаг дэвсгэрийн харъяалал”, “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, хэргийн оролцогч”** сэдвүүдээр хичээл заажээ.

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт Н.Долгорсүрэн нар 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, НҮБ-аас хамтран зохион байгуулсан **“Авлигын эсрэг конвенц Монгол Улсад хэрэгсжиж буй нь”** сэдэвт ярилцлагад оролцож, санал бодлоо солилцжээ.

Улсын Дээд шүүхийн судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн 2009 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Хүний эрхийн үндэсний комисс, Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан **“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжид хийсэн судалгааны тайлан болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн төсөл”** сэдэв хэлэлцүүлэгт оролцсон байна.

Улсын Дээд шүүх, Ханнс Зайделийн сан, түүний Монгол дахь төлөөлөгчийн газар, “Эрх зүйн боловсрол” академитай хамтран Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахуудад зориулсан сургалтыг 2009 оны 6 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулж, сургалтад Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид болон Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслахууд оролцлоо.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим 2009 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүх дээр **дугуй ширээний ярилцлага** хийлээ. Ярилцлагад Улсын Дээд шүүхийн болон Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгчид оролцжээ.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын захиргааны ажилтнууд 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдөр **“Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт”** сэдэвт сургалтад хамрагдлаа.

Эрүүгийн танхимын шүүгчийн туслах- шинжээч Д.Алтанжигүүр Хүний эрхийн үндэсний комисс, “ЭМНЕСТИ интернэшнл” төрийн бус байгууллага, “Монголын уран зургийн галерей”-аас 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хамтран зохион байгуулсан **“Цаазын тавцан дээр”** семинарт оролцжээ.

Судлагааны төвийн Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч Б.Айбек, Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ц.Баярмаа нар 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх төсөл”-өөс зохион байгуулсан **“Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэглэх тухай”** мэргэшүүлэх сургалтад хамрагджээ.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын захиргааны ажилтнууд 2009 оны 12 дугаар сарын 04-ний өдөр “Монгол хэлний найруулга зүй” сэдэвт сургалтад тус тус хамрагджээ.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2009 онд бид амжилт бүтээл арвинтай байлаа. Морилон ирж буй 2010 онд түүнээс ч их зүйлийг хийж, амжуулах шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл гарган ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.